

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны ... дугаар сарын .... -ний өдрийн ..... дугаар тушаалын хавсралт

## **МАЛЫН ЭМЧИД ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ, ЦУЦЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү журмын зорилго нь мал, амьтны өвчний оношлогоо, шинжилгээ, тарилга, туулгалт, боловсруулалт, угаалга, эмчилгээ, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлд хийж байгаа мал эмнэлэг, ариун цэврийн магдлан шинжилгээ, баталгаажуулалт, орчны эрүүл ахуйн үнэлгээ зэрэг мал эмнэлгийн ажил үйлчилгээг гардан гүйцэтгэх мэргэжлийн итгэмжлэл /цаашид “итгэмжлэл” гэх/-ийг сум, дүүргийн малын эмчид олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулхад оршино.

1.2 Итгэмжлэл бүхий малын эмч нь мал эмнэлгийн ажил, үйлчилгээг гардан гүйцэтгэх эрхтэй.

1.3 Малын эмчид итгэмжлэл олгох ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо бүхий байнгын ажиллагаатай магдлан итгэмжлэх Зөвлөл /цаашид Зөвлөл гэх/ гүйцэтгэнэ.

1.4 Зөвлөлийг Малын ерөнхий эмчийн зөвөлснөөр Мал эмнэлгийн газрын даргын тушаалаар байгуулж ажиллуулна.

1.5 Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гарсан эрх зүйн актууд, энэхүү журмыг удирдлага болгоно.

1.6 Зөвлөл нь итгэмжлэлийн сургалтын хөтөлбөр, итгэмжлэлийн шалгалт авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сонгож, итгэмжлэгдсэн малын эмчид олгох “итгэмжлэл”-ийн загварыг баталж хэрэглэнэ.

### **ХОЁР. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ явуулах итгэмжлэл олгох**

2.1. Малын эмч нарын суралцахыг хүссэн сэдвээр ажлын 5 хоногт батаан сестемтэй мэдлэг олгож чадах, итгэмжлэгдсэн сургалт хийх эрх бүхий байгууллага, багыг Итгэмжлэлийн зөвлөл тухай бүр сонгон шалгаруулалтаар шалгаруулж сургалт явуулах эрх олгон, гэрээ байгуулж хамтран ажиллана. Итгэмжлэлийн сургалт нь төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалтын нэг байх болно.

2.2. Итгэмжлэлийг тухайн орон нутагт байнга суурьшин сууж мал эмнэлгийн ажил, үйлчилгээг тогтмол явуулахыг хүссэн, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажиллсан, итгэмжлэлийн сургалтанд хамрагдаж хангалттай дүн үзүүлсэн малын эмчид Зөвлөлийн шийдвэрээр олгоно.

2.3. Итгэмжлэл олгохын тулд Зөвлөл, сургалтын байгууллагатай хамтран боловсруулсан олон сонголттой тухайн суралцагчийн суралцахыг хүссэн хөтөлбөрөөр сургалт явуулан шалгалт /цаашид шалгалт гэх/ авна.

2.4. Шалгалтыг батлагдсан зааврын дагуу олон сонголттой сорилоор авах бөгөөд шалгалтын сорил болон зааврын төслийг Зөвлөл боловсруулж, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар Малын ерөнхий эмч батлан мөрдүүлнэ.

2.5. Анх удаа Итгэмжлэл олгох сургалтанд хамрагдаж, шалалтанд орохыг хүссэн малын эмч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

а/ сургалтанд хамрагдаж итгэмжлэл олгож өгөхийг хүссэн хувийн өргөдөл;

б/ иргэний үнэмлэхний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/;

в/ боловсрол, мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар /баталгаажуулсан/;

г/ 4х6 хэмжээний 2 хувь зураг;

д/ биеийн байцаалт /маягт № 1-ээр/;

2.6. Итгэмжлэл олгох шалгалтанд орох хүсэлтээ гарагсан сум, дүүргийн малын эмч нарын бүрдүүлэх бичиг баримтыг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн алба хүлээн авч бүртгэнэ.

2.7. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн алба нь сум, дүүргийн малын эмч нарыг итгэмжлэл олгохтой холбогдох мэдээллээр хангана.

2.8. Малын эмч нь итгэмжлэл олгох тухай хүсэлтээ аймаг, нийслэлийн мал эмнэлгийн албадаар дамжуулан “Итгэмжлэл” олгох Зөвлөлд 30 хоногийн өмнө гаргана.

2.9. Зөвлөл нь ~~дээд, дунд боловсролтой~~ малын эмчид итгэмжлэл олгох шалгалт авахад баримтлах заавар, сорилын ерөнхий агуулга, чиглэлийн талаарх ~~малын эмч нарт урьдчилан мэдэгдэнэ~~ байнгын мэдээллийг хэвлэл мэдээлэл, веб хуудас, цахим шуудангаар малын эмч нарт тогтмол хүргэж байна.

2.10. ~~Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан бүрэлдэхүүн бүхий комисс~~ Итгэмжлэл олгох зөвлөл нь сум, дүүргийн малын эмч нараас итгэмжлэл олгох шалгалт авна.

2.11. Нийт 75-100 оноо авсан малын эмчийг итгэмжлэл олгох шалгалтанд тэнцсэн гэж үзнэ.

2.12. Итгэмжлэл олгох, эсэх тухай шийдвэрийг шалгалт авч дууссанаас хойш нэг сарын дотор Зөвлөлөөс гаргана.

2.13. Зөвлөл нь шалгалтанд тэнцсэн малын эмчид итгэмжлэлийн гэрчилгээ олгох бөгөөд энэ нь нууцлагдсан код, дугаартай, үнэт цаас байна.

2.14. Шалгалтанд тэнцээгүй малын эмч нь тодорхой хугацаанд давтан сургалтанд хамрагдсаны дараа дахин шалгалт өгөх эрхтэй.

2.15. Шалгалтанд тэнцсэн малын эмчид итгэмжлэлийг 5 жилийн хугацаатайгаар олгоно.

2.16. Малын эмч нь итгэмжлэл олгох сургалт, шалгалтанд орох болон гэрчилгээ авахдаа төлбөр төлөх бөгөөд төлбөрийн хэжээг ~~Хүнс, хөдөө аж ахуйн сайдын~~ Малын ерөнхий эмчийн шийдвэрээр батлана.

### **ГУАВ. Итгэмжлэлийн хугацааг сунгах**

3.1. Итгэмжлэлийн хугацааг дараах шаардлагыг хангасан нөхцөлд сунгана:

а/ мал эмнэлгийн ажил, үйлчилгээ эрхлэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн, ажилладаг нэгж нь стандартын шаардлага хангасан байх; (сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын мал эмнэлгийн байцаагчийн дүгнэлт, тодорхойлолтоор) **50 оноо**

б/ тасралтгүй сургалтанд ~~дунд~~ хамрагдаж 5-н жилийн хугацаанд 5-аас доошгүй кредитийг цуглуулсан байх; **50 оноо**

в/ Кредит бүртгэх дэвтэртэй байна.

**Онооны нийлбэрээр 85-100 оноо авсан малын эмчийн итгэмжлэлээ сунгуулах эрх нээгдэнэ.**

3.2. Итгэмжлэлийн хугацааг сунгахад дараах бичиг баримтыг бүрлүүлнэ:

а/ итгэмжлэлийн гэрчилгээ эх хувиар

б/ сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байцаагч болон үйлчлүүлэгчдийн тодорхойлолт,

в/ ажлын тайлан

г/ тодорхой чиглэлээр сургалтанд хамрагдан, сургалтын кредит хангасан болохыг нотлох баримт /гэрчилгээ, үнэмлэх, диплом г.м/

д/ 4х6 хэмжээний 2 хувь зураг

## **ДӨРӨВ. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаа**

4.1. Зөвлөл нь төрийн захиргааны төв байгууллага, мал эмнэлгийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 9 хүртлэх гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

4.2. Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн даргын шийдвэрээр зарлан хуралдуулна.

4.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Мал эмнэлгийн газрын Хүнс, хөдөө аж ахуйн яамны бланк, тамга, тэмдгийг хэрэглэнэ.

4.4. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудал болон түүнтэй холбогдох бичиг баримтыг хуралдаан эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

4.5. Зөвлөл нь ажлынхаа тайлангаа ~~Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлд~~ Мал эмнэлгийн газрын даргын зөвлөлд жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор танилцуулна.

## **ТАВ. Зөвлөлийн үүрэг**

5.1. Итгэмжлэл олгоход баримтлах заавар, шалгуурыг оновчтой тогтоохын тулд тухайн цаг үеийн эрэлт шаардлагатай уялдуулан зохих судалгаа явуулж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

5.2. Итгэмжлэл олгохтой холбогдуулан малын эмч нарыг тодорхой чиглэл, зөвлөмжөөр хангана.

5.3. Итгэмжлэлийн өмнөх албан ёсны сургалтыг малын эмчийг магадлан итгэмжлэх зөвлөлийн шийдвэрээр сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран буюу дангаар зохион байгуулна.

5.4. Зөвлөл нь итгэмжлэл олгох шалгалтын ажлын хэсгийг арга зүйн удирдамжаар хангана.

5.5. Итгэмжлэгдсэн малын эмчийн судалгааг нэгтгэж, улсын хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөнө.

## **ЗУРГАА. Зөвлөлийн эрх**

6.1. Малын эмчид итгэмжлэл олгох асуудлаар баримтлах чиглэл, шалгуур, сургалтын төлөвлөгөө, кредитийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.2. Зөвлөл нь итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэргэжлийн байгууллага, сургалт хийх эрх бүхий баг, мэргэжилтнийг татан оролцуулна.

6.3. Итгэмжлэлтэй холбогдох асуудлаар тодорхой санал боловсруулж, мэргэжлийн дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

6.4. Итгэмжлэл бүхий малын эмч холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, тухайн байгууллага, орон нутгийн эрэлт, шаардлагыг хангаж ажиллаагүй, мэргэжлийн алдаа гаргасан нь баримтаар тогтоогдвол итгэмжлэлийг хугацаанас нь өмнө цуцалж хүчингүй болгоно.

6.5. Итгэмжлэлтэй болон итгэмжлэлийг цуцлаж хүчингүй болгосон малын эмчийг нийтэд мэдээлнэ.

6.6. Итгэмжлэл олгох шалгалтанд орох хүсэлтээ гаргасан малын эмч нарт холбогдох заавар, зөвлөмж, үүрэг өгөх, шаардлага тавина.

## **ДОЛОО. Хүлээх хариуцлага**

Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.